



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2022/88/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Ж.Назгүл Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanolgii@audit.gov.mn

**ТОЛБО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Х.БАХЫТХАН ТАНАА**

᠒᠐᠒᠒.᠐᠘.᠒5 № ᠒5᠖  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>86,140,739.00</u></b>	<b><u>56,933,546.67</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	26,994,075.33	18,018,900.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	26,994,075.33	18,018,900.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	26,994,075.33	18,018,900.00
31211	Төрийн сангийн харилцах	26,994,075.33	18,018,900.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	12,693,015.67	8,219,018.67
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,985,497.00	
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	10,707,518.67	8,219,018.67
3352	Хувь хүмүүсээс авах авлага	10,707,518.67	8,219,018.67
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	46,453,648.00	30,695,628.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	10,453,648.00	30,695,628.00
35410	Бичиг хэргийн материал	970,330.00	
35420	Аж ахуйн материал	9,483,318.00	30,695,628.00
35600	Мал амьтад	36,000,000.00	
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,247,357,724.14</u></b>	<b><u>1,205,251,683.62</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,247,357,724.14	1,205,251,683.62
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,230,659,724.14	1,188,571,683.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	958,071,931.00	958,071,931.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(286,003,669.50)	(323,274,377.94)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	164,879,994.00	164,879,994.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(150,615,483.64)	(154,933,148.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	575,003,307.00	585,003,307.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(314,764,870.59)	(348,976,927.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,348,468.00	42,348,468.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,205,287.25)	(34,172,384.55)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5,234,600.00	5,234,600.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	360,984,680.00	415,565,880.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(92,423,944.88)	(121,175,657.88)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	150,000.00	-
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	16,698,000.00	16,680,000.00
39301	Програм хангамж	1,486,400.00	1,486,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,450,400.00)	(1,468,400.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,662,000.00	16,662,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,333,498,463.14</u></b>	<b><u>1,262,185,230.29</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,333,498,463.14</u></b>	<b><u>1,262,185,230.29</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,333,498,463.14	1,262,185,230.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	490,884,758.00	490,884,758.00
51101	Өмч: - төрийн	490,884,758.00	490,884,758.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	412,527,915.73	341,214,682.88

51210	Өмнөх үеийн үр дүн	461,786,738.50	412,527,915.73
51220	Тайлант үеийн үр дүн	(49,258,822.77)	(71,313,232.85)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	430,085,789.41	430,085,789.41
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,333,498,463.14</u></b>	<b><u>1,262,185,230.29</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>469,502,081.33</b>	<b>458,038,812.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>469,502,081.33</b>	<b>458,038,812.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	47,577,994.00	64,581,200.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	47,577,994.00	64,581,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	38,635,887.33	31,238,212.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,641,812.00	1,755,637.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,994,075.33	29,482,575.00
131106	Төсвийн урамшуулал	-	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	383,288,200.00	362,219,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	383,288,200.00	362,219,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>518,760,904.10</b>	<b>529,202,044.85</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>518,760,904.10</b>	<b>529,202,044.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	486,521,973.10	504,906,160.85
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	257,358,668.00	235,692,028.00
210101	Үндсэн цалин	170,891,818.00	157,109,952.00
210102	Нэмэгдэл	62,278,450.00	65,983,790.00
210105	Гэрээт ажлын хөлс	24,188,400.00	12,598,286.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,364,652.00	32,112,819.00
210201	Тэтгэврийн даатгал	21,823,352.00	22,157,714.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,635,400.00	2,851,052.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,108,300.00	1,901,473.00
210204	Ажилгүйдлийн даатгал	527,000.00	474,394.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,270,600.00	4,728,186.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	21,370,240.00	19,472,118.00
210301	Гэрэл, цахилгаан	3,678,440.00	2,038,418.00
210302	Түлш, халаалт	17,691,800.00	17,433,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,216,947.47	59,430,825.00
210401	Бичиг хэрэг	2,984,800.00	2,191,500.00
210402	Тээвэр, шатахуун	21,206,407.47	15,381,205.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,025,740.00	1,420,100.00
210408	Бараа материал акталсны зардал	-	40,438,020.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	417,000.00	457,000.00

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	417,000.00	457,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	3,472,800.00
210604	Урсгал засвар	-	3,472,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,708,300.00	3,318,125.00
210702	Дотоод албан томилолт	1,708,300.00	3,318,125.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,423,680.00	1,362,060.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00	132,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420,000.00	352,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	108,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,380.00	193,844.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	23,816.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	418,000.00	439,100.00
210807	Газрын төлбөр	45,600.00	45,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	99,800.00	67,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	145,662,485.63	149,588,385.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,146,075.33	42,610,495.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	944,100.00	440,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99,572,310.30	106,537,240.52
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	32,238,931.00	24,295,884.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	31,197,951.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,197,951.00	
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,040,980.00	24,295,884.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,040,980.00	24,295,884.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(49,258,822.77)</b>	<b>(71,163,232.85)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	150,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	150,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(150,000.00)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(49,258,822.77)</b>	<b>(71,313,232.85)</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	490,884,758.00	430,085,789.41	412,527,915.73	1,333,498,463.14
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	490,884,758.00	430,085,789.41	412,527,915.73	1,333,498,463.14
D08	Тайлант үеийн үр дүн			(71,313,232.85)	(71,313,232.85)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	490,884,758.00	430,085,789.41	341,214,682.88	1,262,185,230.29

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>421,924,087.33</b>	<b>393,457,612.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>421,924,087.33</b>	<b>393,457,612.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	38,635,887.33	31,238,212.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,641,812.00	1,755,637.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,994,075.33	29,482,575.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	383,288,200.00	362,219,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	383,288,200.00	362,219,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>394,480,012.00</b>	<b>402,432,787.33</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>394,480,012.00</b>	<b>402,432,787.33</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>370,034,232.00</b>	<b>378,136,903.33</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	263,881,438.00	235,692,028.00
210101	Үндсэн цалин	177,414,588.00	157,109,952.00
210102	Нэмэгдэл	62,278,450.00	65,983,790.00
210105	Гэрээт ажлын хөлс	24,188,400.00	12,598,286.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35,620,530.00	30,127,322.00
210201	Тэтгэврийн даатгал	25,079,230.00	20,599,975.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,635,400.00	2,423,294.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,108,300.00	1,901,473.00
210204	Ажилгүйдлийн даатгал	527,000.00	474,394.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,270,600.00	4,728,186.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	21,370,240.00	19,472,118.00
210301	Гэрэл, цахилгаан	3,678,440.00	2,038,418.00
210302	Түлш, халаалт	17,691,800.00	17,433,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,216,944.00	19,112,805.00
210401	Бичиг хэрэг	2,984,800.00	2,311,500.00
210402	Тээвэр, шатахуун	21,206,404.00	15,381,205.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,025,740.00	1,420,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	417,000.00	457,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	417,000.00	457,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	300,000.00	3,072,800.00
210604	Урсгал засвар	300,000.00	3,072,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,708,300.00	3,318,125.00
210702	Дотоод албан томилолт	1,708,300.00	3,318,125.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,423,680.00	1,482,060.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00	252,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420,000.00	352,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	108,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,380.00	193,844.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	23,816.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	418,000.00	439,100.00
210807	Газрын төлбөр	45,600.00	45,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	99,800.00	67,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	19,096,100.00	65,402,645.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,152,000.00	64,961,995.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	944,100.00	440,650.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,445,780.00</b>	<b>24,295,884.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	23,404,800.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,404,800.00	
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,040,980.00	24,295,884.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,040,980.00	24,295,884.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>27,444,075.33</b>	<b>(8,975,175.33)</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>450,000.00</b>	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>450,000.00</b>	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	450,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	450,000.00	
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(450,000.00)</b>	=
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	26,994,075.33	(8,975,175.33)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		26,994,075.33
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	26,994,075.33	18,018,900.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	344,200,500.00	326,448,291.00

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	344,200,500.00	326,448,291.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	344,200,500.00	326,448,291.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	246,602,000.00	235,322,328.00
210101	Үндсэн цалин	168,213,500.00	156,740,252.00
210102	Нэмэгдэл	65,290,200.00	65,983,790.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,098,300.00	12,598,286.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,930,800.00	30,081,110.00
210201	Тэтгэврийн даатгал	24,373,800.00	20,553,763.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,639,300.00	2,423,294.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,111,400.00	1,901,473.00
210204	Ажилгүйдлийн даатгал	527,900.00	474,394.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,278,400.00	4,728,186.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,738,400.00	19,472,118.00
210301	Гэрэл, цахилгаан	1,224,700.00	2,038,418.00
210302	Түлш, халаалт	18,513,700.00	17,433,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,685,600.00	18,597,600.00
210401	Бичиг хэрэг	2,311,500.00	2,311,500.00
210402	Тээвэр, шатахуун	14,866,000.00	14,866,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,420,100.00	1,420,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,000.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	500,000.00	457,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	457,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,185,600.00	3,072,800.00
210604	Урсгал засвар	3,185,600.00	3,072,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,250,100.00	3,318,125.00
210702	Дотоод албан томилолт	4,250,100.00	3,318,125.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,603,500.00	1,482,060.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	252,000.00	252,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	352,200.00	352,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	108,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	215,900.00	193,844.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	23,816.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	439,100.00	439,100.00
210807	Газрын төлбөр	45,600.00	45,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	94,800.00	67,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,704,500.00	14,645,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,204,500.00	14,204,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	440,650.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	344,200,500.00	326,448,291.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	344,200,500.00	326,448,291.00
132001	Орон нутгийн төсвөөс	344,200,500.00	326,448,291.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		18,018,900.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00

610002	Төсвөөс гадуур байгууллага		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	26.00	26.00
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	5	5
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>26.0</b>	<b>26.0</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.0	9.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.0	9.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.0	8.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>11,641,812.00</b>	<b>24,694,537.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>11,641,812.00</b>	<b>24,694,537.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	11,641,812.00	24,694,537.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	349,038.00	369,700.00
210101	Үндсэн цалин	349,038.00	369,700.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	43,630.00	46,212.00
210201	Тэтгэврийн даатгал	43,630.00	46,212.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,647,144.00	515,205.00
210401	Бичиг хэрэг	20,000.00	
210402	Тээвэр, шатахуун	1,408,104.00	515,205.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	219,040.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	9,602,000.00	23,763,420.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,602,000.00	23,763,420.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	24,694,537.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	24,694,537.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,755,637.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		22,938,900.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж

заасны дагуу Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 3/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Толбо сумын Засаг даргын тамгын газрын зорилго нь: “Удирдлага болон нөөцийн үр ашгийг дээшлүүлж төрийн үйлчилгээний шуурхай байдал чанар хүртээмжийг сайжруулах”

Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөгөө зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ИТХ, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын алба ажилладаггүй бөгөөд тайлант онд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2019, 2020 оны санхүүгийн баримтын төлөвлөгөөт шалгалт хийгдсэн байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт хөрөнгийн 518.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 71.3 сая төгрөгөөр буюу 5.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	26,994.1	18,018.9	(8,975.2)
Авлага	12,693.0	8,219.0	(4,474.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	46,453.6	30,695.6	(15,758.0)
Үндсэн хөрөнгө	1,247,357.7	1,205,251.7	(42,106.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,333,498.5</b>	<b>1,262,185.2</b>	<b>(71,313.2)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,333,498.5	1,262,185.2	(71,313.2)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,333,498.5</b>	<b>1,262,185.2</b>	<b>(71,313.2)</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 18.0 сая төгрөг болж 9.0 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь иргэдэд тараасан өвсний үнэтэй холбоотой

Авлагын дансны үлдэгдэл 8.2 мянган төгрөг болж 4.5 сая төгрөгөөр буурсан нь иргэдэд тараасан өвсний үнийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 30.7 сая төгрөг болж 15.8 сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн хөрөнгөөр 49.0 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 24.5 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж, ЗДТГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/32 дугаар тоот тушаалаар 1.0 сая төгрөгийн бичиг хэргийн материал, 3.3 сая төгрөгийн аж ахуйн материал, 36.0 сая төгрөгийн мал амьтад, бүгд 40.3 сая төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгө 42.1 сая төгрөгөөр буурсан нь сумын Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 54.6 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, бүгд 64.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021

оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 130 тоот тогтоолоор 0.1 сая төгрөгийн дусаагүй барилга дансанд бүртгэлтэй байсан хөрөнгийг акталж данснаас хасаж, үндсэн хөрөнгөд 106.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлжээ.

Тайлант хугацаанд өр төлбөр гараагүй байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1262,2 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 71,3 сая төгрөгөөр хасагдсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус Засаг даргын тамгын газрын 2021 оны анх батлагдсан төсөв 340.0 сая төгрөг, тодотгосон төсөв 344.2 сая төгрөг болж 4.2 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь хангамж, бараа материалын зардал 6.2 сая, эд хогшил, урсгал засварын зардал 2.0 сая, томилолт, зочны зардал 1.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 0.3 сая, бараа үйлчилгээний бусад зардал төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, цалин хөлс болон нэмэгдэл урамшил 17.3 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 0.7 сая төгрөгөөр тус тус бууруулж тодотгосонтой холбоотой байна.

Анх баталсан төсвийг 10.5 сая төгрөгөөр бараа үйлчилгээний бусад зардлын төсвийг нэмж тодотгон баталжээ.

Толбо сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны 23 дугаар тогтоолоор орон нутгийн орлогын давсан хэсгээс 12.2 сая төгрөгийг төсөл арга хэмжээний зардалд нэмж хуваарилсан байна.

Тайлант онд аймгийн Засаг даргын баталсан төсвийн зохицуулсан хуваариар цалингийн зардлын төсвийг 18.0 сая төгрөгөөр бууруулж зохицуулсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 344.2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 326.4 сая төгрөгийг зарцуулж, төсвийг 17.8 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлж, төсвийн харилцах дансанд 18.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Сумын Орон нутгийн орлогын давсан хэсгээс баталсан 12.2 сая төгрөгийг 11 төсөл арга хэмжээнд зарцуулсан байна.

Нийт төсвийн 72.1 хувийг цалин, 9.2 хувийг НДШ-ийн зардал, 6.0 хувийг тогтмол зардал, 5.7 хувийг хангамж бараа материалын зардал, 0.1 хувийг норматив зардал, 1,0 хувийг урсгал засварын зардал, 1.0 хувийг дотоод томилолтын зардал, 0.4 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 4.5 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 31.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 24.7 сая төгрөгийг зарцуулж, хэмгнэгдсэн 6.5 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг задалж үзэхэд аймгийн Засаг даргаас 0.8 сая төгрөг, Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 0.9 сая төгрөг, худалдасан өвс тэжээлийн үнээс 29.5 сая төгрөг нийтдээ 31.2 сая төгрөгийн орлого хүлээн авч, ажиллагсадтай холбоотой 0.4 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 24.7 сая төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд нийт 344.2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 326.4 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 17.8 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нийт санхүүжилтээс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлыг хасахад 13.4 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 1.3 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба оны эцэст 17.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн тул Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдсан гэж үзлээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд нийт 393.3 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 375.4 сая төгрөгийн 115 мэдээллийг хугацаандаа байршуулж, 17.9 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Шилэн дансны мэдээлэл байршуулсан байдал 90.9 хувьтай байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудад нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан 33.3 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийн биелэлтийг Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12-р сарын 03-ны өдрийн 3/210 тоот албан бичгээр ирүүлжээ.

Зөвлөмжийн биелэлтийг давтан шалгаж үзэхэд шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулж, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгаж зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Харин цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж үндсэн болон нэмэлт дансны санхүүжилтийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй тул гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах нь зүйтэй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 35,9 сая төгрөгийн зөрчил илэрч 18.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 17.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

### **4.1 Залруулсан алдаа**

Залруулсан алдаа байхгүй

### **4.2 Төлбөрийн акт**

Аудитаар 18.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Толбо сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа нийт 326.4 сая төгрөгийг зарцуулж, хэмнэлтээс 17.7 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлж, 18.0 сая төгрөгийг байгууллагын төрийн сан дахь 100021055001 тоот дансанд үлдэгдлээр тайлагнасан байна. Энэ нь тус Тамгын газрын 2021 оны батлагдсан цалингийн зардлын төсвөөс гарсан хэмнэлт байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйл. Төсвийн жил, 7.1-д "Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно", 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт татан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд нийт 393.3 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 375.4 сая төгрөгийн 115 мэдээллийг хугацаандаа байршуулж, 17.9 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Шилэн дансны мэдээлэл байршуулсан байдал 90.9 хувьтай байна.

###### 1.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Толбо сумын ЗДТГ	2	35.9			1	18.0			1	17.9